

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Стратеги төлөвлөгөө үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. Ус цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник технологийн шинэчлэл хийх Зорилтын уялдаа, холбоо: ЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.2.6, 3.4.3.3, аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.11.1, 3.11.4, БОАЖСайдын 2024 оны А/191 дүгээр тушаалаар батлагдсан Хүн төвт хөгжлийн төлөвлөгөөний ҮАЧ-ийн 1.3-ын 20 дугаар арга хэмжээ							
1	Автомат станц тавигдаж түгээмэл бохирдуулагч 6 үзүүлэлтийг хэмжиж агаарын чанарыг мэдээлнэ	Улсын төсөв	Автомат станцын тоо	Байхгүй	1 автоматыг станц тавигдана	2025 оны 05 дугаар сараас Дархан сумын 5-р багт БНСУ-ын Кентек корпорацийн MEZUS110-610 маркийн агаарын чанарын автомат станц тавигдаж түгээмэл бохирдуулагч хүхэрлэг хий, азотот нэгдлүүд, нүүрстөрөгчийн дутуу исэл, озон, PM10, PM2.5 тоосонцор, нийт тоосонцор зэрэг 6 үзүүлэлтийг тасралтгүй хэмжиж эхэлсэн. 2025 оны 12 дугаар сарын байдлаар автомат станцын мэдээг боловсруулах, улсын нэгдсэн сүлжээнд холбох, 2026 оноос мэдээлэх программын хөгжүүлэлт, агаар.mn, MAMIS.mn сайтын сургалт хийгдэж байна.	100%
2	Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт, төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилт	Орон нутгийн төсөв	Тусгасан саналын тоо	2020-2024 оны хөтөлбөрийн 4 арга хэмжээ 100% хэрэгжсэн.	4 арга хэмжээ тусгана	Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 4 арга хэмжээний хэрэгжилт: 1. Төлөвлөгөөний 3.11.1.1.2, 3.11.1.1.3, 3.11.4.1.1 дэх арга хэмжээнүүд 100% хэрэгжсэн. 2. 3.11.4.1.2-т тусгагдсан Дархан сумын 1-3 дугаар багийн орчинд PM10 тоосонцор хэмжигч багаж суурилуулж, агаарын чанарыг үнэлэх арга хэмжээний хэрэгжих хугацаа болоогүй энэ онд багажийн	100%

1	2	3	4	5	6	7	8
						техникийн үзүүлэлтийн судалгаа хийгдсэн, орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгөөр багаж авах саналаа хүргүүлсэн.	
3	Сумдын ЗД-ын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр цаг уур, ус судлалын өртөө, харуулын үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгө оруулалтын санал тусгаж хэрэгжүүлэх	Орон нутгийн төсөв	Тусгасан саналын тоо	Байхгүй	6 арга хэмжээ тусгана	1. Шарын гол сумын Засаг даргын хөтөлбөрт "Шарын гол сумын агаарын чанарын хяналтын харуулын байр шинэчлэх, цаг уурын Шаазгайт өртөөний агаарын бүхээг шинэчлэх" нийт 10.4 сая төгрөгийн төсөл арга хэмжээний хөрөнгийг шийдвэрлүүлж ажлын гүйцэтгэгчээр "Тэгш дүүрэн петролиум" ХХК шалгарч зураг, төсвийн дагуу харуулын ажлын байр баригдаж дуусч 6 дугаар сард хүлээн авсан. 2. Орхон сумын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.2.1-д "Цаг уурын ажиглалтын талбайн хашаа хийх, багаж байрлуулах зориулалтын бүхээг хийх" төсөл арга хэмжээ 5 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хийгдэж 100% дуусч 9 дүгээр сард сумын ЗДТГ-ын ажлын хэсгээс дээрх хөрөнгийг тус төвд албан ёсоор хүлээлгэн өгсөн.	100%
4	Хонгор харуулын цаг уурын ажиглалтын талбайн хашааг шинээр хийх	Орон нутгийн төсөв	Хашааны тоо	1996 онд хашааны тор сольсон	20м*20м хэмжээтэй ажиглалтын талбайг стандартын дагуу шинээр хийнэ	Хонгор сумдын Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.3.5-д тусгагдсан "Цаг уурын ажиглалтын талбайн хашаа, бүхээг шинэчлэх" төсөл арга хэмжээ орон нутгийн 5 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар 100% хийгдэж дуусч 9 дүгээр сард сумын ЗДТГ-ын ажлын хэсэг дээрх хөрөнгүүдийг тус төвд албан ёсоор хүлээлгэн өгсөн. Үр дүн: Цаг уурын ажиглалт, хэмжлийн технологийн заавар (ШЗ.И.01.03.2014) -ын 2.1.4 дэх хэсгийн 19-д заасны дагуу стандарт хангасан хашаа хийгдсэн. <i>(тайланг хавсаргав)</i>	100%
5	Ус судлалын харуулын ажлын байрны эрсдэлийг үнэлж орчин нөхцөлийг сайжруулах	Улсын төсөв	Харуул-ын тоо	2013 онд хаягдал төмөр ашиглаж хашаажуулсан	Хараа-Дархан харуулын ажиглалтын цэгийг хашаажуулж ХАБ-ыг	1. Ус судлалын Шарын гол-Жимс станц харуулын ажиглалтын хашаа 2023 оны үерт эвдэгдэж эрсдэлтэй үнэлэгдсэн. Орхон сумын Засаг даргад /6.0х4.0*2.0м/ 20м урттай хамгаалалтын төмөр хашааг шинээр хийх хүсэлтийг тавьж 2025 оны 5 дугаар сард шийдвэрлүүлсэн.	100%

1	2	3	4	5	6	7	8
					хангана.	2. БОУАӨСайдын 2025 оны А/237 дугаар тушаалаар "Байгаль орчин, цаг уурын салбарын орон нутаг дахь өртөө, харуул байгаль хамгаалагчийн байр (бүсүүдэд) төсөл арга хэмжээний задаргааг шинэчлэн баталж, эрх шилжүүлэх тухай" төсөл арга хэмжээний хүрээнд ус судлалын Хараа-Дархан харуул дээр улсын төсвийн 35,3 сая төгрөгийн харуулын байрыг тендерт шалгарсан И ЭС БИ АЙ ХХК барьж 9 дүгээр сард бүрэн дуусгасан. 3. Ус судлалын Хараа Дархан харуул дээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар харуулын ажлын байр шинээр баригдсан тул ашиглалтын шаардлага хангахгүй болсон хуучин хашааг буулгаж шинээр 30м урттай /6.5м*8.5м*1.5м/ хамгаалалтын хашааг төвийн албан хаагчид өөрсдийн хүчээр барьж байгуулсан.	
6	Утааг давхар шатаадаг эко "Нүүдэлчин С-1" зуухны туршилт хийх	Улсын төсөв	Зуухны тоо	Байхгүй	15ш зуухны туршилт хийгдэж дүнг мэдээлнэ	Нүүдэлчин С-1 зуухыг энгийн гэр зуухтай харьцуулалт хийж мэдээллийг ЦУОШГазар болон аймгийн Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх Ажлын хэсэгт судалгааны үр дүнг танилцуулсан. 1. С-1 зуухны түлшний хэрэглээ энгийн зуухнаас 30-50% хэмнэлттэй. 2. С-1 зуухны хаягдал үнсний хэмжээ энгийн зуухнаас 39-42% бага байна. 3. С-1 зуух энгийн зуух шиг заавал модоор дэмжихгүй, шууд шатаадаг соролт илүү сайтай, нүүрс нь бүрэн шатдаг. 4. С-1 зуухны дулаан барилт 2-4 цаг буюу энгийн зуухнаас 1-3 цаг илүү дулаан барьж байна. 5. С-1 зуухны агаарт утаа хаях хугацааг энгийн зуухтай харьцуулахад 37% бага байна. 6. С-1 зуухны орчим хэмжсэн агаарын чанарыг түгээмэл бохирдуулагч 4 үзүүлэлтийн агууламж энгийн зуухнаас 25-59% бохирдлын хэмжээ бага гарсан.	100%
7	"Агаарын бохирдлыг бууруулах аймгийн дэд хөтөлбөр"-ийн 2 арга	Орон нутгийн төсөв	Тусгасан санал тоо	1 арга хэмжээ хэрэгжсэн,	2 арга хэмжээг 100% хэрэгжүүлнэ	1. Сүүлийн 3 жилийн тооллогын мэдээллийг Дархан 1-р бүсэд 38 ААНБ, Дархан сумын 1, 2, 3, 5, 6, 7, 8, 15, Малчин багийн 6668 айл өрх, Дархан 2-р бүсэд	100%

1	2	3	4	5	6	7	8
	хэмжээний хэрэгжилтийн хангах			1 арга хэмжээний хугацаа болоогүй.		Шарын гол сумын төвийн багууд, Дулаан Шарын гол ТӨХК, Шарын гол ХК-ийн үйлдвэр, 697 айл өрх хамрагдаж, түлсэн нүүрсний хэмжээг тооцоолж гарган бүсийг шинэчлэн тогтоосон. Бүсэд мөрдөх журмын төслийг боловсруулахаар давхардсан тоогоор 500 гаруй иргэн, аж ахуйн байгууллагын саналыг БОГ-тай хамтарч авч нэгтгэсэн. 2. Аймгийн Засаг даргын "Үйл ажиллагааг хориглох тухай" 2025 оны 01-А/14 захирамжаар стандартаас хэтэрч агаар бохирдуулж байгаа ААНБ-уудын нам даралтын зуух ашиглахыг хориглох, дулааны шугамд үе шаттай холбогдох, оршин суух бүртгэлгүй, айлын хашаанд түр оршин суугчийн тоог нэмэхгүй байх тухай шийдвэрлэсэн.	
8	Төвийн 2025-2028 оны Стратегийн хөтөлбөр, төлөвлөгөө батлах, хэрэгжилтийг хангах	Улсын төсөв	Арга хэмжээний тоо	2021-2024 оны стратеги 95 %-тай хэрэгжсэн.	Стратеги төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилтийг 100% хангана.	1. Төвийн 2025-2028 оны стратегийн хөтөлбөр, төлөвлөгөөг 2025 оны А/14 дүгээр тушаалаар баталсан. 2. Стратегийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөнд тусгасан өртөөний газрыг судлаж аймгийн ГЗБ-ын төлөвлөлтөнд тусгуулах, нийтийн хэрэгцээнд гаргадаг мэдээллийн загварыг сайжруулах, шинэчлэх 2 арга хэмжээ хэрэгжээгүй тул 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ.	91.9%
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан 8 арга хэмжээний хэрэгжилт							98.9%

ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Стратеги төлөвлөгөө үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. Шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжүүлж улсын сүлжээний нэгжийн тасралтгүй байдлыг хангах, мэргэжил арга зүйн							

1	2	3	4	5	6	7	8
зөвлөгөөгөөр хангах, шинжилгээ, судалгааны ажил хийх Зорилтын уялдаа, холбоо: Хөтөлбөр батлах тухай ЦУОШГ-ын даргын 2016 оны А/02 тушаал, БОАЖСайдын 2024 оны А/191 дүгээр тушаалаар батлагдсан Хүн төвт хөгжлийн төлөвлөгөөний ҮАЧ-ийн 1.3-ын арга хэмжээ 20, ҮАЧ-ийн 2.1-ийн арга хэмжээ 30							
1	Цаг уурын шинжилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Улсын төсөв	Нэгдсэн хөтөлбөрийн хувь	А/чанар 99.3%, шүүмжийн чанар 99.3%	Ажиглалтын чанар 99.5%, шүүмжийн чанар 99.5%	Цаг уурын шинжилгээний ажлын хөтөлбөр 100% хэрэгжүүлсэн. УЦУОСМХүрээлэнгийн Уур амьсгал өөрчлөлтийн нөөцийн судалгааны хэлтсээс ирсэн жилийн эцсийн дүнгээр 99.6%-тай дүгнэгдэж зорилтот түвшингөөс +0.1% ахисан.	100%
2	Нарны цацраг судлалын AWS-310R автомат станцын хөтөлбөрийн хэрэгжилт-ийг хангах	Улсын төсөв	Нэгдсэн хөтөлбөрийн хувь	Шүүмжийн чанар 99.2%	Шүүмжийн чанар 100%	Нарны цацраг судлалын шинжилгээний ажлын хөтөлбөр 100% хэрэгжсэн. УЦУОСМХүрээлэнгийн Уур амьсгал өөрчлөлтийн нөөцийн судалгааны хэлтсээс ирсэн жилийн эцсийн дүнгээр 100%-тай дүгнэгдэж зорилтот түвшинд хүрсэн.	100%
3	Цаг агаарын урьдчилсан мэдээ зохиох	Улсын төсөв	Мэдээний тоо хувь	Нэгдсэн дүн 98.7 % 5 хоногийн УМ-ний чанар 87.2%	Нэгдсэн дүн 98.73 % 5 хоногийн УМ-ний чанар 89.0%	Мэдээлэл үйлчилгээний ажлын хөтөлбөр 100% хэрэгжсэн. - Цаг агаарын урьдчилсан мэдээний дүн 96.1% - ААМОНч дүн 100% - Аюулта болон гамшигт үзэгдлийг урьдчилсан мэдээлсэн байдал 100% ЦУОШГ-ын Урьдчилан мэдээлэх хэлтсээс ирсэн 2025 оны жилийн эцсийн нэгдсэн дүнгээр 99.0%-иар дүгнэгдэж зорилтот түвшингөөс +0.27%-иар, 5 хоногийн урьдчилсан мэдээний чанар зорилтот түвшингөөс +1.0%-иар тус тус ахисан.	100%
4	ХАА-н цаг уурын шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэх	Улсын төсөв	Хөтөлбөрийн хувь	Ажиглалтын чанар 99.85%, шүүмжийн чанар 100%	Ажиглалтын чанар 100%, шүүмжийн чанар 100%	ХАА-н цаг уурын шинжилгээний ажлын хөтөлбөрийг 100% хэрэгжүүлсэн. УЦУОСМХүрээлэнгийн Хөдөө аж ахуйн цаг уурын судалгааны хэлтсээс: - Мэдээний ирц 100% - Хөтөлбөрийн биелэлт 100% - Ажиглалтын мэдээний бүтэц 100% - Ажиглалтын мэдээний чанар 100% - Шүүмж шалгалт 100% жилийн эцсийн нэгдсэн дүнгээр 100%-иар дүгнэгдэж 2025 оны зорилтот түвшинд хүрсэн.	100%
5	Цаг уурын бүх төрлийн ажиглалт хэмжлийн мэдээг хяналтын	Улсын төсөв	Шуурхай мэдээний чанар	Мэдээ дамжуулалт 99.98%	Мэдээ дамжуулалт 99.98%	1. Цаг уурын өртөө, харуулууд ажиглалтын 7967 мэдээ 100% дамжигдсан. 6 мэдээг хяналтын хугацаанаас 01-03 минут хоцроож дамжуулсан. Хугацаа хоцроосон	100%

1	2	3	4	5	6	7	8
	системээр шуурхай дамжуулах, хяналт тавих					мэдээний тоог 2024 онтой харьцуулахад 6 мэдээгээр буурсан. 2. Арав хоногийн климат мэдээ 72, сарын климат мэдээг 24 удаа зохиож 100% дамжигдсан. 3. Аюул мэдээ 149, давтан аюул 4, агаар мэдээ 142 нийт 295 мэдээг 100%-ийн чанартай дамжуулсан.	
6	Нам өндрийн нислэгт цаг агаарын мэдээгээр үйлчлэх	Улсын төсөв	Мэдээний тоо, чанар	10 нислэгт 64 мэдээ ерөнхий дүнгээр 97.9%	Ерөнхий дүн 98.0%	Эхний 10 сарын байдлаар нисэхийн төлөвлөгөөний дагуу нам өндрийн 40 нислэгт цаг агаарын чиглэлийн урьдчилсан /НИ-5/ 29, ТОИМ ТАФ 68, Дархан хот орчмын район 72 нийт 209 мэдээ мэдээ зохиож MDS цахим хаягаар дамжуулсан. Нисэхийн цаг уурын төвөөс 99.81%-иар дүгнэсэн.	100%
7	Орчны хяналт шинжилгээний ажлыг хөтөлбөрийн дагуу чанартай гүйцэтгэх	Улсын төсөв	Шинжилгээний ажлын чанар	Нэгдсэн Үнэлгээ 99.78%	Нэгдсэн үнэлгээ 100%	Орчны хяналт шинжилгээний ажлын хөтөлбөр 100% хэрэгжсэн. БОХЗТЛ-иос дүгнэсэн дүнгээр: - Усны чанарын хяналт, шинжилгээний дүн 99.7% - Агаарын чанарын хяналт, шинжилгээний дүн 100%, - Хөрсний чанарын хяналт, шинжилгээний дүн 98.0% Нэгдсэн дүнгээр 99.31%-иар дүгнэгдсэн. 2025 оны зорилтот түвшинд хүрээгүй -0.69% буурсан.	99.31%
8	Усны горимын шинжилгээний ажлын хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Улсын төсөв	Шинжилгээний ажлын чанар	Нэгдсэн үнэлгээ 98.7%	Нэгдсэн үнэлгээ 98.8%	Усны горимын шинжилгээний ажлын хөтөлбөрийг 100% хэрэгжүүлсэн. УЦУОСМХүрээлэнгийн Гадаргын усны судалгааны хэлтсээс ирсэн нэгдсэн дүн: - Шинжилгээний ажлын чанар 97.0% - Ирц 99.72% - Урсац бодолтын чанар /2024 он/ 97.2% 2025 оны жилийн эцсийн нэгдсэн дүнгээр 98.5%-тай дүгнэгдэж зорилтот түвшингөөс -0.3%-иар буурсан.	98.5%
9	Бэлчээрийн цөлжилт-ийн мониторингийн хяналт шинжилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	Улсын төсөв	Үнэлгээ	2020 онд нэгдсэн дүн 100%	Нэгдсэн дүн 100%	08 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд бэлчээрийн цөлжилтийн мониторингийн хөтөлбөрт ажлыг Дархан сумын "Төмөр толгой" Хонгор сумын "Хар бэлчирийн ам, Салхит" Орхон сумын "Цогт-Өндөр, Дэлгэр уул, Дардай нуур" Шарын гол сумын "Олон-Хөтөл, Буянт, Дархан-уул нийт 9 цэгээс хөрсний дээж авч орчны бичиглэл болон хөрсний морфологи бичиглэлийг газар дээр нь тодорхойлсон.	100%
10	Мэдээ дамжуулалт, сүлжээний хэвийн	Улсын төсөв	Сүлжээ ашиглалт	Мэдээ дамжуулалт	Мэдээ дамжуулалт	Сүлжээ ашиглалт, тасралтгүй, аюулгүй байдлыг хангаж 100% ажилласан. Мэдээлэл технологи, сүлжээний	100%

1	2	3	4	5	6	7	8
	аюулгүй байдлыг хангах		мэдээ дамжуулалтын чанар хувь	99.98%, сүлжээ ашиглалт 100%	100%, сүлжээ ашиглалт 100%	хэлтсээс ирсэн жилийн эцсийн нэгдсэн дүнгээр 100% дүгнэгдэж зорилтот түвшинд хүрсэн.	
11	Хэмжих хэрэгсэл, багаж төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ, шалгалт тохируулгыг тогтмол хийж хэмжлийн нэгдмэл байдлыг хангах	Улсын төсөв	Баталгаажсан багажийн тоо хувь	.	Нэгдсэн дүн 100%	Багаж төхөөрөмжийн үзлэг үйлчилгээ, шалгалт тохируулгыг хуваарийн дагуу хийж хэмжлийн нэгдмэл байдлыг 100% хангасан. БОХЗТЛ-иос ирсэн дүнгээр багаж тохируулгын үйлчилгээ 100%-иар дүгнэгдэж зорилтдоо хүрсэн. Тайлан боловсруулалт, чанар 97.0%-иар үнэлэгдсэн. Хэмжил зүйн ажил үйлчилгээний 2025 оны нэгдсэн дүнгээр 99.0%-иар дүгнэгдэж зорилтот түвшингөөс -1.0%-иар буурсан	99.0%
12	Шалгалтын багаж болон автомат станцуудыг баталгаа-жуулалтад хамруулах	Улсын төсөв	Гэрчилгээ авсан хэмжих хэрэгсэлийн тоо	ЦУ-ын 3, БОШЛ-ийн 2 хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийгдсэн.	Автомат станц 3, БОШЛ-ийн 5 нийт 8 хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийгдэнэ	1. Цацрагийн түвшний RDS-110 маркийн №230172, №230218 дугаартай 2 багажийг ЦЭАА-ны дозиметрийн лабораторит баталгаажуулалтад хамруулж дахин ашиглах хугацаа сунгагдаж №25/143, №25/144 дугаартай гэрчилгээ авсан. 2. AWS-310 автомат станцуудын ажиллагаа шалгалтанд тэнцсэн A/2025/104, A/2025/105 дугаартай баталгаажуулалтын гэрчилгээ ирсэн. 3. AWSR-310 автомат багажийн нийлбэр болон ойсон цацрагийн пиранометрүүдийг баталгаажуулалтанд явуулж 1 жилийн хүчинтэй 139508, 139509 серийн дугаартай гэрчилгээгээр баталгаажуулсан. 4. Стандарт хэмжил зүйн газраар БОШЛ-т ашиглаж буй UV/VIS, X-ма 1000, спектрофотометр, суурин зөөврийн PH метр, ES метр нийт 5 багажинд шалгалт тохируулга хийгдэж №573,574,575,576,577 дугаартай гэрчилгээ авсан. БОХЗТЛ-иос ирсэн дүнгээр багаж баталгаажуулалт 100%-иар дүгнэгдэж зорилтоо биелүүлсэн.	100%
13	Шинжилгээний ажлын технологийн хяналт, шалган зөвлөх	Улсын төсөв	Салбарын тоо хувь	26 хийгдсэн	Технологийн хяналт, шалган зөвлөх 19	Шинжилгээний ажлын технологийн дотоод хяналт, шалган зөвлөх хуваарь батлагдаж салбаруудад 16 салбар нэгжид дотоод хяналт, шалган зөвлөх ажил хийж дараах зөвлөмжийг өгсөн.	96.3%

1	2	3	4	5	6	7	8
					хийгдэнэ	Цаг уурын чиглэлээр хийгдсэн дотоодын хяналт, шалган зөвлөх ажлын 10 удаагийн дундаж үнэлгээгээр 98.7%-тай, ус судлалын чиглэлээр 6 удаагийн хяналтын дундаж үнэлгээгээр 99.5%-тай, БОШЛ-ийн чиглэлээр хийгдсэн хяналтын дундаж үнэлгээгээр 90.7%-тай тус тус "Хангалттай" дүгнэгдлээ.	
14	Мэдээллийн дэд сангийн үйл ажиллагааг хэвийн явуулах, дэд санд нөхөн бүрдүүлэлт хийх	Улсын төсөв	Нөхөн бүрдүүлэлтийн тоо	Нэгдсэн дүн 99.96%	Нэгдсэн дүн 99.98%	2025 оны мэдээллийн дэд сан, шинжилгээний архивын ажлыг ЦУОШГ-ын АМСХэлтсээс дүгнэсэн дүнгээр: - мэдээллийн дэд сангийн дүн 99.83% - шинжилгээний архивын дүн 99.93% нэгдсэн дүнгээр 99.88%-иар дүгнэгдэж зорилтот түвшингөөс -0.1% -иар буурсан.	99.88%
15	Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагаа явуулах	Улсын төсөв	Ажиллагааны тоо хувь	Ерөнхий үнэлгээ 99.7%	Үнэлгээ 99.7%	Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагааг ЦУОШГ-ын Технологи инновацын хэлтсээс дүнгэсэн дүн: - Удирдлага зохион байгуулалт, бэлэн байдал хангалт- 100%, - ЦАЗН хэрэгцээ болон эрсдлийг үнэлэх - 100%, - Заавар технологи мөрдөлт, ХААА - 100%, - Хээрийн гаралт - 100%, - Тайлан үнэлгээ - 100% 2025 оны жилийн эцсийн нэгдсэн дүнгээр 100%-тай дүгнэгдэж зорилтот түвшингөөс +0.3%-иар ахисан.	100%
16	Дархан-Уул аймгийн 2024 оны уур амьсгал, орчны чанарын төлөв байдлын шинжилгээний ажлыг нэгтгэж тайлан гаргах	Улсын төсөв	Судалгаа-ны тоо	2017 онд шинжилгээний ажлыг нэгтгэж тойм гаргасан.	Дархан-Уул аймгийн 2024 оны уур амьсгал, орчны чанарын төлөв байдлын тойм гаргана.	1. Аймгийн 2024 оны уур амьсгал, орчны чанарын төлөв байдлын тайлан гаргах Ажлын хэсгийг төвийн даргын 2025 оны А/03 дугаар тушаалаар байгуулж судалгааны ажлын төлөвлөгөө батлагдсан. ХААИС-ийн цаг уурын мэргэжлийн багш Д.Амаржаргал (Ph.D, дэд профессор)-тай зөвлөхөөр ажилласан. 2. Дэлхийн ус, цаг уурын өдрийг тохиолдуулан онол практикийн эрдэм шинжилгээний хурал хийх тухай төвийн даргын 2025 оны А/09 дүгээр тушаал гарч МУИС, ШУТИС, ХААИС, Өмнө-говь аймгийн УЦУОШТ зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. ОПЭШ хурлын хөтөлбөрийн дагуу 24 илтгэл хэлэлцүүлж эхний 3 байрт шалгарсан илтгэлийн урамшуулсан. Дээрх илтгэлүүдийг зөвлөмжийн дагуу сайжруулалт хийж эмхэтгэн Дархан-Уул аймгийн Уур	100%

1	2	3	4	5	6	7	8
						амьсгал, орчны чанарын төлөв байдлын бүтээл болгосон.	
17	Шарын гол сумын 2010-2024 оны шинжилгээний ажлыг нэгтгэж уур амьсгал, орчны төлөв байдлын тайлан гаргах	Улсын төсөв	Судалгааны тоо	-	Сумын уур амьсгал, орчны төлөв байдлын тайланг гаргана.	1. Дэлхийн ус, цаг уурын өдрийг тохиолдуулан “Эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоонд учрах саад бэрхшээлийг хамтдаа шийдье” сэдвээр зохион байгуулсан ОПЭШ-ний хуралд Шарын гол сумын уур амьсгалын өөрчлөлт, ургамлын ургалтын хугацааны хур тунадас, бэлчээрийн ургамлын ургацын хоорондын хамаарал сэдвээр 3 илтгэл хэлэлцүүлсэн. 2. Шарын гол сумын уур амьсгалын өөрчлөлтийн судалгааны ажлын тайланг 06 дугаар сард сумын удирдлагуудад танилцуулсан.	100%
18	ХАА-н цаг уурын 2024 оны шинжилгээний ажлын тайланг УЦУОСМХ-ээр хэлэлцүүлэх	Улсын төсөв	Судалгааны тоо	2023 онд 7 бүлэг тайлан гаргасан	2024 оны судалгааны тайланг УЦУОСМХ-ээр хэлэлцүүлж үнэлгээ, зөвлөмж авна	1. 2024 оны Агро цаг уурын шинжилгээний ажлын тайлан 7 бүлэг 51 хуудас тайланд 42 хүснэгт, 38 зураг, дүгнэлт, ашигласан хэвлэлийн жагсаалтаас бүрдсэн тайланг УЦУОСМХ-ийн ХААЦУСХэлтэст 03 дугаар сарын 14-нд илгээсэн. 2. ХААЦУСХэлтсийн ЭШДэд ажилтан Б.Ганцэцэгээс ирсэн зөвлөмжийн дагуу тайланд 16 завсар, сайжруулалт хийж 04 дүгээр сарын 10-нд илгээсэн. 2024 оны Агро цаг уурын шинжилгээний ажлын тайлан Хангалттай үнэлэгдсэн.	100%
Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлсэн 18 арга хэмжээ							99.6%

ГУРАВ. НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин /2024 он/	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
-----	---	-------	------------------	------------------------	-----------------	---	-------------------

1	2	3	4	5	6	7	8
3.1. Удирдлага, санхүү, хүний нөөцийн ил тод байдлыг хангах							
Зорилт 1. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасралтгүй байдал, удирдлага, санхүү, хүний нөөцийн ил тод нээлттэй байдлыг хангах							

1	2	3	4	5	6	7	8
Зорилтын уялдаа: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна 4.4.1.1, 4.4.1.3, Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлнэ 4.5.1.1, 4.5.1.3							
1	Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах	Улсын төсөв	Тоо, хувь	Байгууллагын үйл ажиллагаа ил тод мэдээлэгдсэн.	Үйл ажиллагааг shilen.gov.mn-д бүрэн байршуулж мэдээлэх	1. ЗГ-ын 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын дагуу shilen.gov.mn цахим мэдээллийн сайтад байршуулсан байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын хэрэгжилт жилийн эцсийн дүнгээр 100% -д хүрсэн. 2. 2025 онд нийт 171 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 11 дүгээр сарын 28-ны байдлаар 139 мэдээг 100% оруулж үнэн зөв тайлагнасан. 3. 2025 онд тус төвийн шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажилд хамааралтай Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын болон Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын тушаал нийт 14 шийдвэрийг 100% хэрэгжүүлж ажилласан байна. <i>(дэлгэрэнгүй тайлан хавсаргав)</i>	100%
2	Төвийн 2025-2028 оны хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр болосруулж батлах	Улсын төсөв	Тусгасан саналын тоо	2021-2024 оны хөтөлбөр 95%-тай дүгнэгдсэн	2025 оны хэрэгжилтийг хангаж хугацаанд нь тайлагнах	Төвийн "2025-2028 оны албан хаагчдын ажлах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр" батлагдаж 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт 97.8 хувь буюу "бүрэн хангалттай" үнэлэгдлээ. "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 3 дугаар хавсралтаар тайлагнасан. <i>(тайлан хавсаргав)</i>	100%
3	Албан хаагчийг чадавхжуулах, мэргэшүүлэх сургалтууд зохион байгуулах	Улсын төсөв	Албан хаагчийн тоо	12 сургалтад оролцоо 95%	2025 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	Сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу 8 төрлийн 39 цагийн сургалтад давхардсан тоогоор 115 албан хаагчийг хамруулахаар төлөвлөсөн. Жилийн эцсийн байдлаар сургалт 100% хийгдсэн. 1. Мэргэшүүлэх 8 төрлийн 34 цагийн сургалтад 110 албан хаагч 95.6%-ийн ирцтэй хамрагдаж, чанар 75.7-96.3%-тай үнэлэгдсэн. 2. Төлөвлөгөөт бус (дотоод ба гадаад) сургалтуудад мэргэшлийн ур чадвар дээшилсэн. ✓ Агаарын чанарын автомат станцын чиглэлээр 3	100%

1	2	3	4	5	6	7	8
						удаагийн дадлага сургалтад 3 инженер хамрагдсан. ✓ Усны чанарын MNS4586:2024 болон бусад шинэчилсэн стандартуудтай танилцах, хэрэгжүүлэх сургалтад химийн инженерүүд бүрэн хамрагдаж, стандартыг худалдан авч хэрэглээнд нэвтрүүлсэн. ✓ БНХАУ, БНСУ-д зохион байгуулагдсан олон улсын сургалтад 2 мэргэжилтэн хамрагдсан. ✓ ЦУОШГ-т Урьдчилан мэдээлэх инженер, БОШЛ-ийн усны чанар, Багаж хэмжилзүйн мэргэшүүлэх сургалтад 3 инженер хамрагдав. 3. Орон нутгаас зохион байгуулсан “Найрамдал” төслийн хүрээнд зохион байгуулсан 80 цагийн багц сургалтад 9, Ёс зүй, хууль эрх зүйн сургалтад 10, Гэр бүл, хүүхэд хамгааллын чиглэлийн сургалтад 18 нийт 185 албан хаагч давхардсан тоогоор хамрагдаж салбар хоорондын оролцоог хангах, нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх чадавх нэмэгдсэн. 4. 2025 оны төсөвт сургалттай холбоотой зардал суугдаагүй, жилийн 1077,400 төгрөгийн төсөвтэй томилолтын зардалаас сургалтанд хамрагдсан 8 албан хаагчид 811.600 төгрөг олгосон. Томилолтын зардалын 75%-ийг сургалтад зарцуулсан. 5. Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан боловсон хүчний тоо, гадаад, дотоод хамтын ажиллагааны сургалтууд нэмэгдсэн нь байгууллагын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх зорилт биелэгдсэн.	
4	Хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг журмын дагуу хийх	Төсөв шаарда х-гүй	Сонгон шалгаруулалтын тоо	8 орон тоо зарлагдсан	Журмын дагуу ажлын байранд ил тод нээлттэй сонгон шалгаруулалт хийгдэх	Ажлын байрны зар мэдээллийг https://darkhan-uul.namem.gov.mn сайт, ХХҮГ-ын зарын систем, байгууллагын “Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв” фэйсбүүк пэйж, Zangia.mn зэрэг мэдээллийн сувгуудаар ТҮ-ний бага албан тушаал жижүүр, үйлчлэгчийн орон тооны зарыг 4 удаа явуулахад 5 иргэн утсаар мэдээлэл авсан, 3 иргэнээс хүсэлт ирсэнг журмын дагуу шалгаруулж 2 иргэнийг түр ажлаар хангасан. 2025 онд мэргэжлийн боловсон хүчин	100%

1	2	3	4	5	6	7	8
5	Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг стандартын дагуу хөтлөх	Улсын төсөв	Тоо, хувь	Ирсэн 114, явсан 163 бичгийн шийдвэрлэлт 100%	Төвийн үйл ажиллагаатай холбоотой үүсэн хөтлөгдөж байгаа баримт бичгийг стандартын дагуу хөтөлсөн тоо, хувь	тогтвор суурьшилтай ажилласан. 2025 оны сүүлийн хагас жилд нийт 108 албан ирсэнийг бүртгэж холбогдох албан тушаалтанд танилцуулж баримт бичгийн MNS 5140:1-2021, MNS 5140:2-2021, MNS 5140:3-2021 стандартын дагуу бүртгэл хөтлөн ажилласан. Ирсэн албан бичгийн хэрэгжилт: Хариу хүссэн албан бичиг 47 ирсэнээс ✓ Албан бичгээр хариуг хүргүүлсэн-11 ✓ Мейл хаягаар хүргүүлсэн- 6 ✓ Сургалтанд хамрагдах тухай-8 ✓ Нийтэд хамааралтай бичиг-9 ✓ Судалгаа ирүүлэх-1 ✓ Агаар, хөрсний шинжилгээ хийх-6 нийт 41 албан бичгийг хугацаанд шийдвэрлүүлж хариуг хүргүүлж ажилласан. Явсан албан бичгийн шийдвэрлэлт Нийт 178 албан бичиг явсанаас: ✓ Хариу хүссэн бичиг-42 ✓ Ирсэн бичгийн хариуг хүргүүлсэн 11 ✓ Албан хаагчийн тодорхойлолт-4 ✓ Цаг агаарын мэдээ хүссэн-9 ✓ Үндсэн үйл ажиллагаатай холбоотой хөрөнгө хүссэн-7 ✓ Тендэртэй холбоотой мэдэгдэл, гэрээ байгуулах 5	100%
6	Албан бланкны загварыг хос бичгээр үйлдэж батлуулах, албан хаагчдын өрөө тасалгааны хаягийг монгол, крилл бичгээр үйлдэх	Улсын төсөв	Тоо, чанар	Өрөөний хаягийг хос бичгээр үйлдсэн.	А5 албан бланкны загварыг батлуулж, албан бичиг үйлдэж турших, нийт 16 өрөө тасалгааны хаягийг монгол, крилл хос бичгээр	1. ЗГ-ын 2020 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан Монгол бичгийн үндэсний хөтөлбөр, Төрийн албан хэргийг хос бичгээр хөтлөх зөвлөмжийн дагуу А5, А4, хэвлэмэл хуудсыг MNS-6395:2022 стандартын дагуу эх бэлтгэн аймгийн Архивын тасгийн дарга Н.Баярбаатараар батлуулж үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2. Төвийн даргын 20 тушаал, 50 албан бичгийг хос бичгээр үйлдэгдэн гаргасан. 1. Нийт 16 өрөөний хаягыг хос бичгээр үйлдэж хаягжуулсан. Бүтэц зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан дахин 6 албан өрөө,	100%

1	2	3	4	5	6	7	8
7	Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэл хангах	Улсын төсөв	Тоо, чанар	2019 онд 65 үзүүлэлт-ээр хангалттай үнэлэгдсэн.	үйлдэх Улсын үзлэгт бэлтгэх удирдамж батлуулж хэрэгжилтийг ханган ажиллах	хүүхдийн өрөөний хаяг хийгдсэн. 1. Архив албан хэрэг хөтлөлтийн улсын удирдамж батлуулж хэрэгжилтийг 100% ханган ажилласан. 2. Байгууллагын архивын баримтанд тооллого хийх ажлын хэсэг даргын 2025 оны А/33 дугаар тушаалаар байгуулагдаж 09 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд тооллого хийгдсэн. Тооллогоор байнга хадгалах 98 х.н, 70 жил хадгалах 71 х.н, түр хадгалах 306 х.н нийт 475 х.н тоологдсон. Тооллогоор илэрсэн сэлбэн засах шаардлагатай байнга хадгалах 2022-2023 оны 22 баримт, 2019-2022 оны түр хадгалах 54 баримтын баталгааны хуудас, дотоод товъёогны гарын үсэг, цагаан цаасаар үдсэн баримтыг бор хавтасаар үдэж сэргээн засварлах ажил 100% хийгдсэн.	100%
8	Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх	Төсөв шаарда х-гүй	Өргөдөл, гомдлын тоо	Өргөдөл гомдлыг 100% шийдвэрлэж, 4 удаа тайлагнасан.	Хуулийн хугацаанд шийдвэрлэж, 4 удаа тайлагнах	2025 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын үйл ажиллагаа, төрийн албан хаагчтай холбоотой гомдол, санал ирээгүй 58 хүсэлт ирсэнг шийдвэрлэсэн тухай: 1. Төвийн захиргаанд 3 иргэнээс ажилд орох хүсэлт ирсэнг журмын дагуу шалгаруулж 2 иргэнийг ажлаар хангасан 2. Албан хаагчдаас ирсэн 55 хүсэлтийг байгууллагын дотоодод хэрэгждэг журмуудаар зохицуулж 100% шийдвэрлэсэн. Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд 4 удаа тайлагнасан.	100%
9	Авлига, ашиг, сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө батлан хэрэгжүүлж ажиллах	Улсын төсөв	Тоо, хуь	Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө 100% хэрэгжсэн.	Авлига, ашиг, сонирхол, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	Тус байгууллагын ЁЗДХорооны төлөвлөгөөнд 3 зорилтын 20 арга хэмжээ тусгагдаж 100%-тай хэрэгжсэн. 1. 2025 оны 3 дугаар сард УА-иас зохион байгуулсан "Ёс зүйн дэд хороодын гишүүдийг чадавхжуулах" сургалт, Зангиа.мн академийн багш Ц.Оюунгэрэлийн "Ажилтны ёс зүй ба хариуцлага" сэдэвт хичээлийг судлаж ёс зүйн чиглэлээр чадавхжсан. 2. 5 дугаар сарын 02-14-ний өдрүүдэд Монголын эмэгтэйчүүдийн академийн академич, доктор, дэд профессор Ж.Оюун Хүний хөгжил сэдвийн хүрээнд "Монгол үндэстэн-Монгол хүний бахархал", "Хүний мэдвэл зохихуй хууль", "Ёс зүйтэй ирээдүй хойч" зэрэг дэд сэдвээр хийгдсэн цуврал 12 цагийн танхимын	100%

1	2	3	4	5	6	7	8
						сургалтад 30 албан хаагч хамрагдсан. 3. УЦУОШТ-Ёс зүйн дэд хороо нэртэй facebook пэйж ТАХ-ын ёс зүй, харилцаа, хандлага, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн контентуудыг албан хаагчдад таниулан ажиллаж байна 4. Шинээр ажилд орсон, хүүхэд асрах чөлөөний хугацаа дуусч ажилд орсон ажилтанд Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаар мэдээлэл танилцуулга хийж албажуулан ТАХ-ийн хувийн хэрэгт хийсэн. 5. ТАХ-ын ёс зүйн тухай хуулиар 5 минутын рийл хийж УЦУОШТ-Ёс зүйн дэд хорооны facebook пэйж хуудсаар танилцуулсан.	
3.1. Удирдлага, санхүү, хүний нөөцийн ил тод байдлыг хангах 9 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь							100%
3.2. Санхүү, нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх							
10	Төсвийг зөв төлөвлөж санхүүгийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, өглөг, авлага үүсгэхгүй ажиллах	Улсын төсөв	Өглөг, авлагын тайлангийн тоо	Батлагдсан төсөв хүрээнд зөрчилгүй ажилласан	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр төлбөр үүсгэхгүй.	1. Батлагдсан төсвийн хүрээнд анхан шатны баримтын бүрдлийг ханган, холбогдох зориулалт, эдийн засгийн ангиллаар байр ашиглалтын тогтмол зардалд 22.4 сая төгрөг, хангамж, бараа материалын зардалд 9.3 сая төгрөг, нормативт зардалд 0.1 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 3.1 сая төгрөг, дотоод албан томилолтын зардалд 1.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг үйлчилгээний зардалд 9.5 сая төгрөгийг тус тус зарцуулж гүйлгээ хийгдсэн. 2. Туслах үйл ажиллагааны орлого өссөн дүнгээр 31,8 сая төгрөгийг төвлөрүүлж журмын дагуу зарцуулах хүсэлтийг 2025 оны 11 дүгээр сард ЦУОШГазарт албан бичгээр хүргүүлсэн. 3. 2025 онд 1,733.2 сая төгрөгийн төсөв батлагдсан ч бүтцийн өөрчлөлт, цомхотгол хийгдэж 08 дугаар сарын 28-нд 1,627.6 сая төгрөг буюу 105.6 сая төгрөгөөр хасагдсан. Оны эхний 11 сарын байдлаар гэрэл цахилгаан, шатахуун, хангамж, бараа үйлчилгээ, багаж техник хэрэгсэл дээр нийт 43,5 сая төгрөгийн өглөг үүссэнг ЦУОШГ-аас 12 дугаар сарын	100%

1	2	3	4	5	6	7	8
						төсөвт зохицуулалт хийж шийдэхээр болсон.	
11	Санхүүгийн анхан шатны бүртгэлийг стандартын дагуу хөтлөх, эд хариуцагч /нярав/-ийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, тайланг хянаж баталгаажуулах	Улсын төсөв	Тайлангийн тоо	Батлагдсан төсвийг зарцуулж, биелэлтийг 100% хангаж ажилласан	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100% хангана.	1. Санхүүгийн анхан шатны бүртгэл: ✓ Нягтлан бодох бүртгэлийг анхан шатны хүчин төгөлдөр баримтыг үндэслэн харилцах дансны 12 тайлан, цалингийн тооцооны тайлан 12 нийт 24 тайланг бэлтгэсэн. ✓ Эхний 11 сарын байдлаар төсвөөс цалин хөлсний зардал 1,145.8 сая, НДШ-ийн зардал 152.0 сая, бусад ургал зардал 24.0 сая төгрөгийг зарцуулсан. ✓ Нэмэлт санхүүжилтээс цалин хөлсний зардал 210.5 сая, НДШ-ийн зардал 27.5 сая, бусад зардал 2.0 сая төгрөгийг зарцуулсан. 2. Бараа материалын 12, үндсэн хөрөнгийн 4 нийт 16 тайланг хянаж, баталгаажуулж, эд хариуцагчид 2 зөвлөмж өгсөн.	100%
12	Эд хөрөнгийн тооллогыг зохион байгуулах, өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад хяналт тавих	Улсын төсөв	Эд хөрөнгийн тооллогын дүн, хувь	ТӨБЗГ-ын гэрээ 91% дүгнэгдсэн.	ТБОНӨ-ийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ТӨБЗГ-ын гэрээг 92% дүгнүүлэх	1. ТӨБЗГ-аас ирж гэрээ дүгнээгүй байна. 2. 2025 оны А/17 дугаар тушаалаар эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогын ажлын хэсгийг, 2025 оны А/39 дүгээр тушаалаар жилийн эцсийн тооллогын ажлын хэсгийг тус тус байгуулж тооллогын ажил зохион байгуулах журмыг танилцуулж, чиглэл өгч ажилласан. Хөрөнгийн шилжилт, хөдөлгөөн дутуу хийгдсэн, бараа материалын зарим ангилал давхардсан, зөрсөн, дутуу бүртгэлтэй зөрчлүүд илэрсэнг тооллогын явцад арилгасан. 3. Өмчийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт: ТӨБЗГ-ын 2025 оны 457 дугаар тогтоолоор нийт 5,767,200 төгрөгийн үндсэн хөрөнгө актлах шийдвэр ирж, 7,256,120 төгрөгний УАЗ-фургон авто машины актлах шийдвэрлэгдээгүй. Дээрх 5,767,200 төгрөгний үндсэн хөрөнгийг акталж, устган хэрэгжилтийг ЦУОШГ-т тайлагнасан. ЦУОШГ-аас суурин компьютер, хашааны сараалжин төмөр, төмөр шон, борооны пуужин, удирдлага нийт 19.593.455.05 төгрөгний нийлүүлэгдсэн хөрөнгө, ХАА-гаар 26,311,600 төгрөгийн үнэ бүхий компьютер,	100%

1	2	3	4	5	6	7	8
						техник хэрэгсэл, Орхон, Хонгор сумаас 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн цаг уурын ажиглалтын 2 хашааг орлогод авч, данс бүртгэлд тусгасан. 4. Төрийн болон орон нутгийн өмчийн цахим мэдээллийн систем (umch.sgov.mn)-д санхүүгийн тайлан, хөрөнгийн эхний үлдэгдэл, хөдлөл өөрчлөлт, зөрүүг залруулан шивж, 03 дугаар сарын 30-ны дотор үнэн зөв илгээж тайлагнасан. 5. ТӨБЗГ-аас umch.sgov.mn системийн шинэчлэл хийхтэй холбогдуулан тус төвийн ӨХБЗ-тэй хамтарч III улирлын байдлаар үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл нь 1,447.5 сая төгрөг, элэгдэл тооцож цахим системд хугацаанд нь бүртгэж үлдэх өртөг 1,095.3 сая төгрөгний үндсэн хөрөнгөнд хяналт тавьж ажилласан.	
13	Худалдан авах ажиллагааг зохион байгуулах	Улсын төсөв	Хэрэгжилтийн хувь	ХАА-ны журмын хэрэгжилтийг хангаж ажилласан	ТБОНӨХБАҮХА тухай хуулийн хэрэгжилтийг ангаж ажиллах	Тайлант хугацаанд 26.3 сая төгрөгийн "Багаж, тоног төхөөрөмж" худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар 3 удаа зарлаж, шаардлагад нийцсэн оролцогчоор Онцот есөнбулаг ХХК шалгарч 1 дүгээр багц компьютер, техник хэрэгслийг 17,464,970 төгрөгөөр, 2 дугаар багц тусгай зориулалтын тоног төхөөрөмжийг 8,846,630 төгрөгөөр нийлүүлэхээр 2025 оны 05 дугаар сарын 28-нд гэрээ байгуулж ТБОНӨХБАҮХА тухай хууль, журмын дагуу ажилласан. ХАА-ны тайланг ЦУОШГ-т 2025 оны тайланг 6 дугаар сард илгээсэн.	100%
14	Тайлан бүх мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн, үнэн зөв тайлагнах	Төсөв шаардахгүй	Тайлангийн тоо, хувь	100% тайлагнасан.	5 төрлийн 32 мэдээг 100% тайлагнаж, хэрэгжилтийг хангах	1. Шилэн дансны цахим ситем shilendans.gov.mn системд 11, улирлын тайланг 4 удаа шивж 100% тайлагнасан. 2. Байгууллагын санхүүгийн ил тод байдлын самбарт батлагдсан төсөв, төсвийн хуваарь, аудитын тайлан, бүтэц орон тооны тушаал, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг 100% байршуулсан. 3. Аудитын хэрэгжилтийг цахимд https://fas.audit.mn/#/ 2025 оны Y/30-ны өдөр байршуулж илгээсэн. 4. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг сар бүрийн 05-ны өдрийн дотор нийт 11 удаа тайлагнаж	100%

1	2	3	4	5	6	7	8
						баталгаажуулсан. 5. https://auth.itc.gov.mn/ системд татварын ТТ-11, ТТ-12 тайланг улирал бүр тайлагнаж, баталгаажуулсан. 6. Санхүүгийн 2024 оны жилийн эцсийн тайланг 2 дугаар сарын 15, 2025 оны хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 22, III улирлын тайланг 10 дугаар сарын 15-ны дотор e-balance.gov.mn систем рүү илгээж баталгаажуулсан.	
15	Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь иж бүрэн бэлтгэж, тайлагнах	Төсөв шаардахгүй	Мэдээний тоо	28 төрлийн 170 мэдээг хугацаанд нь, 1 мэдээг хугацаа хоцроосон	171 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлэх	1. 2025 онд нийт 171 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 11 дүгээр сарын 28-ны байдлаар 139 мэдээг 100% оруулж үнэн зөв тайлагнасан. 2. 2025 оны 3-р улирлын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас шалгасан дүнгээр 135 мэдээг хугацаанд нь бүрэн байршуулж 100%-иар дүгнэгдсэн.	100%
3.2. Санхүү, нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлийг хэрэгжүүлэх 6 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь							100%
3.3. Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээ							
16	Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд дээд шатны байгууллагын бодлогыг тусгах, уялдаа холбоог хангаж байгаад хяналт, үнэлгээ хийх	Төсөв шаардахгүй	Үнэлгээний тоо, хувь	2021-2024 оны стратеги төлөвлөгөө 95 %-тай хэрэгжсэн	Зорилт арга хэмжээнд үнэлгээ хийгдэх	Төвийн 2025-2028 оны стратегийн хөтөлбөр, төлөвлөгөөнд салбарын 2, нийтлэг 15 хуулийг бүрэн тусгасан байгууллагын зорилго, чиг үүрэгтэй нийцсэн, тодорхой бүтэцтэй 3 үндсэн чиглэл, 9 дэд чиглэл, 38 арга хэмжээ нь хэрэгжих боломжтой, бодит тооцоололд тулгуурласан, стратегийн баримт бичиг нь зорилтод нийцсэн, уялдаа холбоотой, хэрэгжих боломжтой гэж дүгнэсэн.	100%
17	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх	Төсөв шаардахгүй	Үнэлгээний тоо, хувь	2024 оны тайлан 98.8 %-тай хэрэгжсэн	Зорилт арга хэмжээнд үнэлгээ хийгдэх	2025 онд төлөвлөгөөнд тусгасан өртөөний газрыг судлаж аймгийн ГЗБ-ын төлөвлөлтөнд тусгуулах, нийтийн хэрэгцээнд гаргадаг мэдээллийн загварыг сайжруулах, шинэчлэх 2 арга хэмжээ хэрэгжээгүй тул 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд оруулах, цаашид стратегийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж байхыг зөвлөмж болголоо.	
18	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг	Төсөв шаардахгүй	Үнэлгээний тоо, хувь	shilen.gov.mn 76.2 оноогоор	shilen.gov.mn хяналт, үнэлгээ хийх	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг shilen.gov.mn сайтаар орж шалгахад хэрэгжилт 100%-д хүрсэн байна. Цаашид цахим сайтадуудад	100%

1	2	3	4	5	6	7	8
	хянаж үнэлгээ, дүгнэлт өгөх			үнэлэгдсэн		мэдээллийг цаг хугацаанд нь оруулж ил тод байдлыг хангаж ажиллахыг зөвлөмж болгож байна.	
	2.3. Дотоод хяналт-шинжилгээ үнэлгээний 3 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь						
	Гурав. Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 19 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь						

ДӨРӨВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Стратеги төлөвлөгөө үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
Зорилт 4. Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн үйл ажиллагааг ард иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сурталчилах, мэдээллээр үйлчлэх Зорилтын уялдаа, холбоо: Ус цаг уур орчны шинжилгээний салбарын стратеги төлөвлөгөөний Зорилт-5-ын 1, 2, 5, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль, 2016 оны А02, Цаг уур орчны шинжилгээний газрын даргын 2016 оны А02 тушаал "Хөтөлбөр батлах тухай", Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоолын хүрээнд							
1	Цаг агаарын урьдчилсан мэдээллээр үйлчлэх	Улсын төсөв	Үйлчилсэн мэдээний тоо	9 төрлийн 22324 удаа үйлчилсэн	9 төрлийн 22350 удаа үйлчилэх	Үйлчилсэн мэдээллийн төрөл, тоо: 1. 12 цагийн нарийвчлалтай мэдээ 365 2. 1 хоногийн мэдээ 365 3. 5 хоногийн мэдээ 365 4. 7 хоногийн мэдээ 48 5. 1-11 сарын мэдээ 11 6. Улирлын төлөв 4 7. Анхааруулга 150, сэрэмжлүүлэх 7 8. Түймрийн эрсдэлийн 131 9. Тусгай зориулалтын мэдээ 49 10. Хоногийн тойм 365 11. 7 хоногийн тойм 52 нийт 1903 мэдээллийг 22685 давтамжтай үйлчилсэн. Үр дүн: 2025 оны мэдээллийн тоог 2024 онтой харьцуулахад үйлчилгээ 1.6%-иар нэмэгдсэн.	100%
2	ХААЦУ-ын тойм, зөвлөмж, урьдчилсан мэдээллээр үйлчлэх	Улсын төсөв	Үйлчилсэн мэдээний тоо	УМ-ний таарц 98.9%, 54 мэдээллээр	УМ-ний таарц 99.0%, 54 мэдээллээр үйлчилэх	1. Жил, улирлын тойм 10, удаа, 10 хоногийн тойм 36, хаврын тариалалтын үеийн болон мал төллөх үеийн зөвлөмж 2 нийт 48 2. Хөрс гэсэх, хөлдөх хугацаа, хаврын хөрсний угтвар	100%

1	2	3	4	5	6	7	8
				үйлчилсэн		чийгийн, буудайн бутлалт, гололтын үе шат илрэх хугацааны буудайн аарцан бололт, буудайн ургац урьдчилсан мэдээ 6 нийт 54 мэдээг darkhan-uul.weather.gov.mn сайт, Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төв фэйсбүүкийн фэйж хуудасд байршуулж иргэд, хэрэглэгч болон аймгийн ОБГ, ХХААГ, сумдын ЗДТГ-т шуурхай үйлчилсэн.	
3	Голуудын усны үерийн сэрэмжлүүлэг мэдээгээр үйлчлэх	Улсын төсөв	Үйлчилсэн мэдээний тоо	45 удаагийн сэрэмжлүүлэг мэдээгээр үйлчилсэн.	Нөхцөл бүрдсэн үед голуудын усны үерийн сэрэмжлүүлэг мэдээгээр үйлчлэх	1. Дархан хот орчмоор хаврын шар усны үерийн эрсдэлийн үнэлгээ III буюу бага түвшинд үнэлэгдсэн мэдээллийг DBS тв-д ярилцлага өгч олон нийтэд мэдээлсэн. 2. Аймгийн ОБГ-ын UOKshtab@nema.gov.mn хаягаар хаврын шар усны үерийн усны түвшин, хур тунадасны хэмжээ, одоогийн нөхцөл байдлыг өмнөх оны мөн үетэй харьцуулсан судалгаа гаргаж өдөр бүр аймгийн ОК, ХЕГСГЗ, ДСЦТС зэрэг газруудад үйлчилсэн. 3. Дархан-Уул аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв фэйж хуудсаар хаврын шар усны үерийн анхааруулга мэдээг 25 удаа, намрын мөсний үзэгдлийн анхааруулга мэдээг 3 удаа зохиож олон нийтэд түгээж үйлчилсэн.	100%
4	Аймгийн 2024 оны агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого, бүртгэлийн ажлыг зохион байгуулах, тооллогын дүн мэдээ тайлан гаргах	ОН-ийн төсөв	Эх үүсвэрийн тоо	Тооллого хийгдэж тайлан гарсан.	Агаарын бохирдлын эх үүсвэрийн тооллого, бүртгэлийн ажлыг зохион байгуулах, тооллогын дүн мэдээ тайлан гаргах	1. 2024 оны АБЭҮТ-ын нэгдсэн тайлан 2025 оны 3 дугаар сард гарч аймгийн хэмжээнд ✓ 3-15кВт зуух 7935 тоологдож өмнөх оноос 0.9%-иар буурсан. ✓ 15-100кВт 33 зуух тоологдож өмнөх оноос 10%-иар нэмэгдсэн. ✓ 100-4200кВт 13 ААНБ-ын 20 яндангийн 22 зуух тоологдож өмнөх оноос 22.4%-иар нэмэгдсэн. (Хонгор, Шарын гол суманд 4 ААНБ-ын 6 зуух нэмж тоологдсон) ✓ 4200кВт түүнээс дээш зуухтай 2 ААНБ тоологдсон. ✓ Аймгийн хэмжээнд хөдөлгөөнд оролцож байгаа 27215 тээврийн хэрэгсэл тоологдож өмнөх оноос 2.5% нэмэгдсэн. 2. Аймгийн Засаг дарын захирамжаар байгуулагдсан	100%

1	2	3	4	5	6	7	8
						агаарын бохирдлыг бууруулах ажлын хэсгээс 2024 оны тооллогын дүнд тулгуурлан 28 ААНБ-ын 15-100кВт яндангийн утаан дээр хэмжилт хийхэд 7 зуух MNS5457:2005 стандартын хүлцэх дээд хэмжээнээс давсан бохирдолтой, 8 зуух зориулалтын бус түлш түлсэн нь тогтоогдсон. Үр дүн: Тооллогын дүнг үндэслэн аймгийн Засаг даргын 2025 оны 01-А/14 захирамж гарч стандартаас хэтэрч агаар бохирдуулж байгаа ААНБ-уудын нам даралтын зуух ашиглахыг хориглох, дулааны шугамд холбох, оршин суух бүртгэлгүй, айлын хашаанд түр оршин суугчийн тоог нэмэхгүй байх шийдвэр гарсан. 2025 оны АБЭҮТ-ын ажил 11 дүгээр сарын 20-ноос 2026 оны 03 дугаар сарын 15-ны хооронд явагдах бөгөөд дээрх захирамжийн хэрэгжилтийг хангаж тайлагнана.	
5	Тусгай хэрэгцээний мэдээллээр үйлчлэх	Улсын төсөв	Үйлчилсэн мэдээний тоо	89 х.н ашиглаж үйлчилсэн	Иргэд ААН-д тусгай хэрэгцээний мэдээллээр үйлчлэх ашиглаж үйлчилэх	Шинжилгээний архивын 01 хөмрөгийг ашиглан тусгай хэрэгцээний дараах төрлийн мэдээллээр үйлчилсэн. Үүнд: 1. Нийт 18 иргэн, 7 ААНБ-д үйлчилж 2,194,800 төгрөгний орлогыг төсөвт төвлөрүүлсэн 2. Цахим үйлчилгээнд зориулсан "E-Archives" цахим вэбийг хэрэглэгчдэд санал болгон сурталчилж 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдөр, 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрүүдийн агаарын температурын дундаж мэдээлэл авах тухай зөвлөж үйлчилсэн. 3. Байгаль орчин, ус, цаг агаар, уур амьсгалын талаарх архивын мэдээллийг цахимжуулж, лавлагааг олон сувгаар чирэгдэлгүй авах боломжийг бүрдүүлж байна.	100%
6	ААНБ-уудын үйлдвэрлэлийн орчны бохирдлыг хянаж сорилтын дүнгээр үйлчлэх	Улсын төсөв	сорилын тоо	42 ААНБ-ын 411 сорилт гүйцэтгэсэн.	43 ААНБ-ын 414 сорилт гүйцэтгэсэн	2025 онд шинээр 2 аж ахуй нэгж хамтран ажиллах гэрээ байгуулсан. Гэрээтэй 45 ААНБ-уудын үйлдвэрлэлийн орчинд агаарын 182 сорьц, усны 97 дээж, хөрсний 179 дээж, цацрагийн 16 нийт 474 дээж авсан. 2024 оны дээжтэй харьцуулахад 15%-иар нэмэгдсэн. 1. Уул уурхай, барилгын материал олборлогч 9 ААН-ийн үйлдвэрлэлийн орчинд тоос, тоосонцрын агууламж MNS4585:2025 стандартаас 1.1-6.6 дахин	100%

1	2	3	4	5	6	7	8
						давсан 2. Хаягдал усны химийн шинжилгээгээр 4 ААНБ MNS4943:2015 стандартаас 1.2-3.0 дахин давсан 3. Хөрсний MNS5850:2018 стандарт дахь хөрсөн дэх органик бохирдуулах бодис шинжилгээгээр 1 ААН-ийн газрын тосны бүтээгдэхүүний агууламж 1.0 дахин давсан ААНБ-ууд үйл ажиллагаатай холбоотой орчинд бохирдол илэрч байгааг БОГ болон холбогдох газруудад хүргэсэн, дээрх ААНБ-уудад технологийн шинэчлэлт хийж бохирдлыг багасгах шаардлага тавьсан.	
7	"Нээлттэй өдөрлөг" зохион байгуулж сурталчилгаа хийх	Улсын төсөв	Зохион байгуулсан тоо	Суманд 1, аймагт 1 зохион байгуулсан	Уур амьсгалын өөрчлөлт, судалгааны ажлын тайлан мэдээ, бүтээгдэхүүн үйлчилгээг олон нийтэд сурталчилна	1. 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр олон улсын худалдааны төвд аймгийн ОБГазартай хамтран "Түймэргүй төрх-Бидний хариуцлага" нөлөөллийн аяны үйл ажиллагаанд оролцож ухаалаг киоск дэлгэцээр darkhan-uul.weather.gov.mn/ сайтыг сурталчилж иргэдийн сонирхсон асуултанд хариулж иргэдээс санал хүсэлтийг авсан. Орон нутгийн DBS тв, Дархан-Уул аймаг, Цэц.мн зэрэг мэдээллийн хэрэгслээр Цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедицийн үйл ажиллагаа, 5 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээ, хуурайшил түймэр гарах нөхцөл байдлын талаар ярилцлага өгсөн. 2. 2025 оны 10 дугаар сарын 29-нд нээлттэй өдөрлөгийг "Номин агуулах худалдаа"-ны төвд хийж иргэдэд 2025-2026 оны өвлийн улирлын прогноз танилцуулах, darkhan-uul.weather.gov.mn сайтаас үйлчилгээ авах, өнөдөр настангуудын гар утсанд Ус, цаг уурын мэдээлэл түгээдэг пэйж хуудсыг дагагчаар оруулж хэрэглэгчийн тоог нэмэгдүүлсэн. Тус өдөрлөгийн үеэр авсан санал асуулгаар иргэдийн 83% нь байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөл ажил, амьдралд мэдрэгддэг, 65-78% цаг агаарын мэдээг өдөр бүр ашигладаг, 55.1% урьдчилан сэргийлэх зорилгоор ашигладаг судалгаа гарсан. Цаашид цаг агаар аюултай болон гамшигт үзэгдлээс	100%

1	2	3	4	5	6	7	8
						эртнээс сэрэмжлүүлэх анхааруулгыг олон хүнд түгээж 75%-д хувьд хүргэнэ.	
	Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ						100%
	НИЙТ 51 АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ						99.6%

ТАЙЛАГНАСАН:

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

ЕРӨНХИЙ ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР

ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



А.БАТГЭРЭЛ

Б.САЙНЖАРГАЛ

Д.ОТГОНЧИМЭГ

---oOo---oOo---